

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ӨМА-2026/05-15-ШТА-НА

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ,
ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА.



Даланзадгад хот 2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор С.Одончимэг

Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn

Аудитор А.Ганзуузай

Утас: 70533552 Цахим хаяг: Ganzuuzai@audit.gov.mn

Аудитор М.Номиндарь

Утас: 70533552 Цахим хаяг: Nomindarim@audit.gov.mn

Аудитор Н.Хулан

Утас: 70533552 Цахим хаяг: Khulann@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар
авна уу: Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	2
ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	2
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	4
БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БОДИТ НӨЛӨӨЛЛӨӨР ХЭМЖИГДЭХ, ҮР ӨГӨӨЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ЭРЭМБЭЛЖ, ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	6
А.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон богино дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан хэдий ч нэн тэргүүний хэрэгцээ, шаардлага, үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй байна.....	6
А.2 Төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж байгаа нь хэрэгжилт удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх шалтгаан болж байна.....	7
БҮЛЭГ 2. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦҮҮЛЭН БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ, ДОТООД ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	11
Б.1 Худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүдийн хариуцлага, ур чадварыг дээшлүүлээгүй, гомдлын мөрөөр холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна.	11
БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	15
В.1 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжүүлээгүй, гэрээний дагуу хариуцлага тооцож, холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.....	15
В.2. Барилга байгууламжийн үе шат бүрд зохиогчийн хяналтаар илэрсэн зөрчил дутагдал өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, захиалагчийн хяналтыг чанартай хэрэгжүүлэх шаардлагатай байна.....	23
В.3 Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмжийг зориулалт, хүчин чадлын дагуу ашиглалтад оруулж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцож ажиллах шаардлагатай байна.	25
ДҮГНЭЛТ	31
ЗӨВЛӨМЖ	33
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАХ ТУШААЛ.....	34

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ШТА	Шууд тайлагнах аудит
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХАА	Худалдан авах ажиллагаа
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХА	Харьцуулалтын арга
ШХА	Шууд худалдан авалт
ГШБА	Гэрээ шууд байгуулах арга
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	ОНТХО-ын 2025 оны төлөвлөлт	6
Хүснэгт 2	Орон нутгийн өмчлөлд шилжих боломжгүй төсөл арга хэмжээ	7
Хүснэгт 3	ИТХ-ын тогтоолоор баталсан 2025 оны төсөл, арга хэмжээ тоо, төсөвт өртөг	7
Хүснэгт 4	Зураг төсөвгүй 9 төсөл, арга хэмжээний жагсаалт	8-9
Хүснэгт 5	Магадлалын дүгнэлтгүй 8 төсөл, арга хэмжээний жагсаалт	9
Хүснэгт 6	Ижил төстэй зураг төсөв боловсруулах төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн харьцуулалт	10
Хүснэгт 7	Санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэгш хуваарилаагүй төсөл, арга хэмжээ	10-11
Хүснэгт 8	ХАА-ны гүйцэтгэл	11
Хүснэгт 9	ХАА-нд мөрдөгдсөн журам	13
Хүснэгт 10	Хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй ХАА	13
Хүснэгт 11	Төсөл арга хэмжээний гэрээний хэрэгжилтийн байдал	15
Хүснэгт 12	Төсөл арга хэмжээнд олгосон санхүүжилт	16
Хүснэгт 12	ОНТХО-аар 2025 онд хийгдэх барилга, байгууламжийн ажил	23
Зураг 1	Сэврэй сумын 10 айлын орон сууцны барилгын гадна тохижилт хийгдээгүй байдал	18
Зураг 2	Ханхонгор сумын 10 айлын орон сууцны барилгын гадна тохижилт хийгдээгүй байдал	18
Зураг 3	Ханбогд сумын Онцгой байдлын хэлтсийн сургалтын төвийн барилга	18
Зураг 4	Улсын нөөцийн 114 дүгээр салбарын байр, агуулахын барилгын засварын дараах зураг	19
Зураг 5	Гурвантэс сумын дунд сургуулийн барилга	19
Зураг 6	Ханбогд сумын Цагдаагийн хэлтсийн барилга	19

Зураг 7	Даланзадгад суман дахь Тэмээний төрөлжсөн мал эмнэлгийн барилга	20
Зураг 8	Цогтцэций сумын Эрүүл мэндийн төвийн Great Wall Tank 500 маркийн автомашин	20
Зураг 9	Тэгш дүүрэн тохижилт ОНӨААТҮГ-ыг хог хаягдал тээвэрлэх машин	21
Зураг 10	Тэгш дүүрэн тохижилт ОНӨААТҮГ-ын барилга	21
Зураг 11	Ноён сумын 10 айлын орон сууцны барилгын ажлын явц	22
Зураг 12	Цогтцэций сумын 10 айлын орон сууцны гадна тохижилтын ажлын явц	22
Зураг 13	Худалдааны төв зах"-ын барилга байгууламж	25
Зураг 14	Булган сумын худалдаа, үйлчилгээ, мэдээллийн төвийн барилга	25
Зураг 15	Даланзадгайн цэцэрлэгт хүрээлэнгийн сургалт мэдээллийн төвийн барилга	26
Зураг 16	Даланзадгад сум дахь Тэмээний төрөлжсөн мал эмнэлгийн барилга	26
Зураг 17	Даланзадгад сум дахь Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмж	26
Зураг 18	Цогт-Овоо суманд барьсан мал нядалгааны газрын барилга	27
Зураг 19	Ханхонгор сум дахь хог шатаах зуух	27
Зураг 20	Чандмань 9 дүгээр багийн чийрэгжүүлэлтийн талбай	27
Зураг 21	Зүүнсайхан 5 дугаар баг, Дундсайхан 4 дүгээр багийн тоглоомын талбай	28
Зураг 22	Сэврэй сумын төрийн үйлчилгээний авто машины гаражийн барилга	29
Зураг 23	Даланзадгад сумын 7-р багт баригдсан 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга	29
Зураг 24	Тэгш дүүрэн тохижилт" ОНӨААТҮГ-ын хог тээвэрлэх 3 дугуйт мотоцикл	29
Зураг 25	Гурвантэс сумын залуучуудын хөгжлийн төвийн барилга	30
Зураг 26	Сэврэй, Цогт-Овоо сумын ахмадын өргөөний барилга	30

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/179 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилго

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэсэн. Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх?
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж, хяналт тавьсан эсэх?
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, хууль журмын дагуу санхүүжүүлж, бүртгэлд тусгасан зориулалтын дагуу ашигласан эсэх?

Аудитын хамарсан хүрээ

Аудитад түүврийн арга ашиглан Өмнөговь аймагт 2025 онд орон төсвийн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол улсын аудитын стандарт MNS 6817-5:2020, гүйцэтгэлийн аудитын зарчим MNS 6817-6:2020, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад асуудлын шинжилгээний дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Засгийн газрын 2021 оны 160 дугаар, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”

- Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"
- Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"
- Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"
- Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалаар баталсан "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар"
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд
- Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон холбогдох бусад эрх зүйн актууд.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор С.Одончимэг, аудитор А.Ганзуузай, М.Номиндарь, Н.Хулан нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Хүндрэл бэрхшээл:

Аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 673,473.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 555 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 314,165.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 112 барилга байгууламж, 120,627.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 33 автозам дэд бүтцийн төсөл арга хэмжээг тус тус хэрэгжүүлсэн байна.

Орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагын хүн хүчний нөөц хязгаарлагдмал, нарийн мэргэжлийн боловсон хүчин хангалтгүй байгаа нь хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтэд мэргэжлийн дүгнэлт гаргах боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Иймд цаашид тус аудитад нарийн мэргэжлийн шинжээч татан оролцуулах саналтай байна.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БОДИТ НӨЛӨӨЛЛӨӨР ХЭМЖИГДЭХ, ҮР ӨГӨӨЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ЭРЭМБЭЛЖ, ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

А.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон богино дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан хэдий ч нэн тэргүүний хэрэгцээ, шаардлага, үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй байна.

1.1. Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 сарын 18-ны өдрийн 03/14 дүгээр тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 256 төсөл, арга хэмжээг 409,683.7 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна.

1.2. Төсөвт тодотгол хийж 2025 оны 08 сарын 07-ны өдрийн 6/19 дүгээр тогтоолоор 261 төсөл, арга хэмжээг 394,875.4 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна.

1.3. Мөн 11 сумын ИТХ-ын тодотголоор 2025 онд нийт 294 төсөл, арга хэмжээг 278,597.74 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт 1: ОНТХО-ын 2025 оны төлөвлөлт

(сая.төгрөг)

№	Аймаг, сумд	2024 оны 12 сард баталсан төлөвлөлт		2025 оны тодотголоор баталсан төлөвлөлт	
		ТАХ-ний тоо	Дүн	ТАХ-ний тоо	Дүн
1	Өмнөговь аймаг	256	409,683.7	261	394,875.4
2	Баяндалай			1	250.0
3	Баян-Овоо	7	414.0	12	414.0
4	Гурвантэс	36	6,461.8	36	6,461.7
5	Даланзадгад	51	22,886.1	50	25,389.9
6	Манлай	3	349.0	2	277.0
7	Ноён	6	509.6	3	476.0
8	Сэврэй	5	638.7	4	709.4
9	Ханбогд	82	175,743.50	85	198,367.6
10	Ханхонгор	2	63.0	2	63.0
11	Цогт-Овоо	2	270.0	3	278.5
12	Цогтцэций	80	29,261.7	96	45,910.6
	НИЙТ	530	646,281.0	555	673,473.1

Эх сурвалж: ИТХ-ын тогтоолууд

1.4. Тухайн онд шинээр хэрэгжүүлэх 379 төсөл арга хэмжээнээс барилга, байгууламж ангилалд 71, автозам, дэд бүтэц ангилалд 20, их засвар, тохижилт ангилалд 102, тоног төхөөрөмж ангилалд 137, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бусад ангилалд 49 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

1.5. Аймгийн 2025 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 14,446.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Ойрын жилүүдэд шинээр баригдах, засварлах барилга байгууламж, шугам сүлжээний зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах, зөвлөх үйлчилгээ авах” ажлыг төлөвлөж, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах 80 төсөл, арга хэмжээг 8,694.6 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр гэрээ байгуулагдсан байна.

1.6. Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24¹-д заасантай нийцэхгүй, Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй 492.9 төсөвт өртөг бүхий 2

¹ “Төсвийн хөрөнгө оруулалт” гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг

төсөл, арга хэмжээ, хувийн өмчлөлд шилжих 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл арга хэмжээ, төсвийн хөрөнгөд бүртгэх боломжгүй 655.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна. Үүнд:

Хүснэгт 2: Орон нутгийн өмчлөлд шилжих боломжгүй төсөл арга хэмжээ (сая төгрөг)

№	Аймаг, сумд	Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй ТАХ		Хувийн өмчлөлд шилжих ТАХ		Төсвийн хөрөнгөд бүртгэх боломжгүй	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймаг	-	-	-	-	2	518.0
2	Баян-Овоо	-	-	-	-	1	20.0
3	Гурвантэс	1	165.0	-	-	-	-
4	Даланзадгад	-	-	-	-	1	78.1
5	Ханбогд	-	-	-	-	2	39.7
6	Цогтцэций	1	327.9	1	20.0	-	-
	НИЙТ	2	492.9	1	20.0	6	655.8

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолууд

1.7. Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг аймгийн Засаг дарга болон холбогдох сумдын Засаг дарга нарт хүргүүллээ.

А.2 Төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж байгаа нь хэрэгжилт удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх шалтгаан болж байна.

1.8. Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор нийт 555 төсөл арга хэмжээнд 673,473.1 сая төгрөг баталснаас өмнөх оноос шилжсэн 176 төсөл, арга хэмжээнд 361,798.8 сая төгрөг, шинээр хэрэгжүүлэх 379 төсөл арга хэмжээнд 311,676.4 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

Хүснэгт 3: ИТХ-ын тогтоолоор баталсан 2025 оны төсөл, арга хэмжээ тоо, төсөвт өртөг (сая.төгрөг)

№	АЙМАГ, СУМДЫН НЭР	ШИЛЖИХ ТАХ		ШИНЭ ТАХ	
		ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн
1	Өмнөговь аймаг	96	247,040.7	165	147,834.7
2	Баяндалай	0	0	1	250.0
3	Баян-Овоо	2	85.0	10	329.0
4	Гурвантэс	10	898.4	26	5,563.3
5	Даланзадгад	14	3,677.2	36	21,712.7
6	Манлай	0	0	2	277.0
7	Ноён	0	0	3	476.0
8	Сэврэй	1	251.0	3	458.4
9	Ханбогд	32	108,460.9	53	89,906.6
10	Ханхонгор	0	0	2	63.0
11	Цогт-Овоо	0	0	3	278.5
12	Цогтцэций	21	1,385.5	75	44,525.2
	ДҮН	176	361,798.8	379	311,674.4

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолууд

1.9. Баян-Овоо сумын ИТХ-ын "Сумын 2025 оны төсвийн тодотгол батлах тухай" 6/3 дугаар тогтоолоор 5 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг тусгаагүй батлуулсан, Ханбогд сумын 2025 оны төсөвт он дамжин хэрэгжих 3 төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийг анхны төсөвт өртгийн дүнгээр батлуулаагүй, Цогтцэций сумын ИТХ-ын 2024.12.27-ны

өдрийн “2025 оны төсөв батлах тухай” 2/4 тогтоолын хавсралтуудыг 2025.01.20-ны өдрийн 3/3 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан байна.

1.10. Иймд Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2², 33.2.6³ дахь заалтын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Баян-Овоо, Ханбогд, Цогтцэций сумдын Засаг дарга нарт зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлээ.

1.11. Он дамжин хэрэгжих нийт 260.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг төсөвт тусган батлуулаагүй байна. Үүнд:

- “Алслагдсан сум, багийн нутагт үүрэн холбооны сүлжээний тархалтыг нэмэгдүүлж, өрх бүрд өндөр хурдны интернэт, утасны сүлжээ хүргэх боломжийг бүрдүүлэх” (Сэврэй сумын Бүйлсэн багийн үүрэн холбооны антен засварлах);
- “Алслагдсан багийн нутагт үүрэн холбооны сүлжээний тархалтыг нэмэгдүүлж, өрх бүрд өндөр хурдны интернэт, утасны сүлжээ хүргэх боломжийг бүрдүүлэх” (Сэврэй сум Хоолт баг).

1.12. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оноос барилга байгууламж, авто зам, дэд бүтэц ангилалд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 17 төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁴, 29¹ дүгээр зүйлийн 29¹.2.2⁵ -д заасан сүүлийн 2 жилийн хугацаанд магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй байх шаардлагыг хангаагүй байна. Үүнд:

- Зураг төсөвгүй 64,639.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 төсөл, арга хэмжээ;
- Магадлалын дүгнэлтгүй 22,087.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 4: Зураг төсөвгүй 9 төсөл, арга хэмжээний жагсаалт (сая.төгрөг)

№	Аймаг, сумд	Төслийн нэр	Төлөвлөсөн төсөвт өртөг	Магадлалаар хянасан төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт
1	Өмнөговь аймаг	Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн эмч нарын орон сууцыг Уламжлалт эмнэлгийн зориулалтаар засварлах	543.0	0.0	0.0
2	Өмнөговь аймаг	Цогтцэций суманд 320 хүүхдийн хүчин чадал бүхий сургуулийн барилга барих ажил,	8,100.0	17,870.2	9,770.2
3	Өмнөговь аймаг	Сэврэй сумын Цагдаагийн хэсгийн барилга барих	350.0	0.0	0.0
4	Баян-Овоо	Баян-Овоо сумын 10/0.4кВ-ын АТП-2 дэд өртөөний ачааллыг хувааж 250кВа чадалтай дэд өртөө шинээр байгуулах, ухаалаг тоолуур шинэчлэх зураг төсвийн хамт	272.0	0.0	0.0

² 33.2 "Төсөвт дараах зүйлийг тусгаж, батална

³ 33.2.6 "хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, төслийн код, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, анхны төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн"

⁴ 29.4 "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана",

⁵ 29¹.2.2 "барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх"

Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

5	Баян-Овоо	Айл өрхийн цахилгаан дулааны эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах, ТЭЗҮ-ийн хамт	1,200.0	0.0	0.0
6	Ханбогд	"Ханбогд сумын 2 дугаар сургуулийн багш ажилчдын 60 айлын орон сууцны шинээр барих"	8,740.2	8,298.2	-442.0
7	Ханбогд	1200 хүүхдийн сургуулийн барилга шинээр барих	37,570.0	43,964.2	6,394.2
8	Цогтцэций	Цахилгаан эрчим хүчний шугамын хүчдэлийг нэмэгдүүлж дэд станц шинээр барих	4,564.0	0.0	0.0
9	Цогтцэций	Тэгш дүүрэн тохижилт ОНӨААТҮГ-н гаражийн барилга, хашаа, гадна тохижилт, гадна шугам сүлжээний ажил	3,300.0	0.0	0.0
НИЙТ			64,639.1	70,132.6	15,722.4

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгаа

Хүснэгт 5: Магадлалын дүгнэлтгүй 8 төсөл, арга хэмжээний жагсаалт (сая.төгрөг)

№	Аймаг, сумд	Төслийн нэр	Төлөвлөсөн төсөвт өртөг	Магадлалаар хянасан төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт
1	Өмнөговь аймаг	Даланзадгад сумын 2-р сургуулийн гадна биеийн тамирын талбайн тохижилт	368.8	0.0	0.0
2	Өмнөговь аймаг	Цогтцэций 10 кВ зүүн ЦДАШ-ын ачааллыг бууруулах зорилгоор сумын төвд ЦДАШ шинээр хийх	329.0	0.0	0.0
3	Өмнөговь аймаг	Даланзадгад сумын Нисэх хорооллын үерийн сувгийн автомашины гүүрэн гарц байгуулах	638.9	0.0	0.0
4	Өмнөговь аймаг	Даланзадгад сумын 2-р баг Хан-Уул гэр хорооллын чулуун зам барих	571.3	1,282.7	711.4
5	Өмнөговь аймаг	Алслагдсан сум, багийн нутагт үүрэн холбооны сүлжээний тархалтыг нэмэгдүүлж, өрх бүрд өндөр хурдны интернэт, утасны сүлжээ хүргэх боломжийг бүрдүүлэх, гурвалсан үйлчилгээ нэвтрүүлэх /Манлай, Цогт-Овоо, Баяндалай, Сэврэй, Ханхонгор, Мандал-Овоо, Хүрмэн, Булган, Ноён, Баян-Овоо/,	3,300.0	0.0	0.0
6	Өмнөговь аймаг	Аймгийн Нутгийн удирдлагын ордны өргөтгөлийн барилгыг барьж, ашиглалтад оруулах	8,500.0	8,464.3	-35.7
7	Даланзадгад	Нийтийн бүжгийн өргөө байгуулах	479.6	0.0	0.0
8	Ханбогд	280 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих	7,900.0	12,936.7	5,036.8
НИЙТ			22,087.6	22,683.7	5,712.5

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгаа

1.13. Иймд Өмнөговь аймгийн Засаг дарга болон Гурвантэс, Даланзадгад, Ханбогд, Цогтцэций сумдын Засаг дарга нарт зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлээ.

1.14. Төсөв батлагдсан болон гэрээ байгуулж, ажил эхлүүлснээс хойш магадлалын дүгнэлт баталгаажиж байгаа нь төсөвт өөрчлөлт орох нөхцөл байдлыг бий болгож байгаад

анхаарч зураг төсөв нь магадлалаар баталгаажаагүй арга хэмжээ төлөвлөхгүй байх шаардлагатай байна.

1.15. 2025 онд аймаг, Даланзадгад, Гурвантэс, Ханбогд, Цогтцэций сумд шилжих 28, шинээр хэрэгжих 38, нийт 66 зураг төсөв, зөвлөх үйлчилгээний төсөл, арга хэмжээ төлөвлөсөн байх бөгөөд ижил төстэй зураг төсвийн төсөвт өртөг харилцан адилгүй байна.

Хүснэгт 6: Ижил төстэй зураг төсөв боловсруулах төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн харьцуулалт

№	Зураг төсвийн нэр	төсөл төлөвлөсөн	төсөвт өртөг	төсөл төлөвлөсөн	төсөвт өртөг	зөрүү дүн
1	320 хүүхдийн сургуулийн барилгын зураг төсөв	Аймаг	150.0	Гурвантэс	90.0	60.0
2	960 хүүхдийн сургуулийн барилгын зураг төсөв	Ханбогд	500.0	Аймаг	280.0	220.0
3	200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг төсөв	Аймаг	120.0	Даланзадгад	69.6	50.4
4	Цэцэрлэгийн өргөтгөлийн зураг төсөв	Цогтцэций	100.0	Ханбогд	40.0	60.0
5	Нутгийн удирдлагын ордон, ЗДТГ-ын барилгын зураг төсөв	Аймаг	120.0	Ханбогд	80.0	40.0
6	60 айлын орон сууцны барилгын зураг төсөв	Ханбогд	185.0	Цогтцэций	59.9	125.1

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгаа

1.16. Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29¹.2.2⁶-д зааснаар сүүлийн 2 жилийн хугацаанд хийгдсэн зураг төсөвтэй байх шаардлагатай бөгөөд судалгаа хийх, зураг төсөв боловсруулах төслүүдийн гүйцэтгэл, бодит ажил болоогүй зураг төсөв, ТЭЗҮ-д дүн шинжилгээ хийж, зураг төсвийг хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөх шаардлагатай байна.

1.17. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025-2026 онд хэрэгжүүлэхээр баталсан нийт 8 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5⁷ дахь заалтад заасны дагуу хэрэгжих хугацаанд тэгш хуваарилж төлөвлөөгүй байна.

Хүснэгт 7 : Санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэгш хуваарилаагүй төсөл, арга хэмжээ

№	Аймаг, сум	Төсөл, арга хэмжээний нэр	эхлэх	дуусах	төсөвт өртөг /	/сая төгрөг/ 2025 онд санхүүжих дүн /
1	Өмнөговь	Цогтцэций суманд 640 хүүхдийн хүчин чадал бүхий сургуулийн барилга барих	2025	2026	20,987.0	4,197.4
2	Өмнөговь	Гурвантэс суманд 320 хүүхдийн сургуулийн барилгыг барьж, ашиглалтад оруулах	2025	2026	13,999.9	4,510.6

⁶ 29¹.2.2 "барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх"

⁷ 29.3.5. шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;

3	Өмнөговь	Цогтцэций сумын дулаан, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний өргөтгөл хийх	2025	2026	5,700.0	1,710.0
4	Өмнөговь	Хог боловсруулах үйлдвэрт нэгдүгээр шугамын тоног төхөөрөмж нийлүүлэх	2025	2026	1,000.0	200.0
5	Өмнөговь	Дата төвийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор тоног төхөөрөмжөөр хангах	2025	2026	2,100.0	420.0
6	Өмнөговь	Гурвантэс сумын газрын үерийн гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор үерийн хамгаалалтын суваг, далан байгуулах	2025	2026	3,782.7	850.0
7	Цогтцэций	320 хүүхдийн хүчин чадал бүхий сургуулийн барилгын ажил эхлүүлэх	2025	2026	17,870.2	4,000.0
8	Цогтцэций	Цогтцэций сумын нийгэм эдийн засаг, дэд бүтцийн суурь судалгааг боловсруулах	2025	2026	1,000.0	300.0
		Дүн			66,439.9	16,188.0

Эх сурвалж: Аймаг, сумын ИТХ-ын тогтоол

1.18. Цаашид он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэгш хуваарилж төсөвт үзүүлэх ачааллыг тэнцвэржүүлэх нь зүйтэй байна.

БҮЛЭГ 2. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦҮҮЛЭН БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ, ДОТООД ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Б.1 Худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүдийн хариуцлага, ур чадварыг дээшлүүлээгүй, гомдлын мөрөөр холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна.

2.1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12-р сарын 18-ны өдрийн “2025 оны төсөв батлах тухай” 3/14 дүгээр тогтоолыг үндэслэн 2024 оны 12 сарын 31-ны өдөр 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна.

2.2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжихээр баталсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг аймгийн Засаг дарга Худалдан авах ажиллагааны газар, сумдын Засаг дарга нарт олгосон байна.

Хүснэгт 8: ХАА-ны гүйцэтгэл

№	Аймаг, сумд	сая төгрөг					
		Зохион байгуулагдсан ХАА		ХАА амжилттай		ХАА амжилтгүй, зарлаагүй	
		TAX	Төсөвт өртөг	TAX	Гэрээний үнийн дүн	TAX	Төсөвт өртөг
1	Аймаг	171	102,439.2	155	83,159.2	16	14,789.6
2	Баяндалай	2	327.0	2	326.8	-	-
3	Баян-Овоо	12	414.0	5	105.8	7	327.0
4	Гурвантэс	20	5,025.3	18	4,666.2	2	180.0
5	Даланзадгад	60	31,453.2	57	25,905.3	3	5,310.5
6	Манлай	4	4,235.0	4	4,228.7	-	-
7	Номгон	1	216.0	1	215.9	-	-
8	Ноён	3	476.0	2	36.0	1	440.0
9	Сэврэй	8	3,134.4	8	3,122.2	-	-
10	Ханбогд	50	89,861.6	50	68,008.1	-	-
11	Ханхонгор	4	189.1	4	178.8	-	-

12	Хүрмэн	1	124.3	1	108.5	-	-
13	Цогт-Овоо	7	1,385.5	6	1,369.5	1	8.5
14	Цогтцэций	87	62,909.0	58	52,180.4	29	8,997.1
	Дүн	430	302,189.7	371	243,611.4	59	30,052.7

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгаа

2.3. Тайлант онд Худалдан авах ажиллагааны газар, сумдын Засаг дарга нар 302,189.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 430 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

2.4. Үүнээс 371 худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулан 243,611.4 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан бол нийт 30,052.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34 худалдан авах ажиллагаа амжилтгүй болж 25 худалдан авах ажиллагаа зарлагдаагүй байна.

2.5. Энэ нь шаардлагад нийцсэн оролцогч шалгараагүй, Монополын эсрэг газарт гомдол гарсан, ажлын даалгавар боловсруулаагүй, тухайн онд хэрэгжүүлэх шаардлагагүй болсон зэргээс шалтгаалсан байна.

2.6. Худалдан авах ажиллагааны 39.7 хувийг аймгийн Худалдан авах ажиллагааны газар, 13.9 хувийг Даланзадгад, 11.6 хувийг Ханбогд, 20.2 хувийг Цогтцэций, 4.6 хувийг Гурвантэс сумд тус тус зохион байгуулсан байна.

2.7. Ханбогд сум 89,861.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 50 ажилд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан бөгөөд тайлант онд худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулаагүй, тендер хүлээн авах хугацааг мөрдөөгүй, захиалагчийн шийдвэрийг хуулийн хугацаанд хүргүүлээгүй зэрэг зөрчил нь худалдан авах ажиллагааг хариуцсан мэргэжилтэн байхгүй, үнэлгээний хорооны гишүүдийг мэргэжил арга зүйгээр хангаагүйтэй холбоотой байна.

2.8. Аймгийн Засаг даргын 2025 оны А/36, А/159 дугаар "Эрх шилжүүлэн, ажил гүйцэтгүүлэх тухай" захирамжаар 1,028.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл арга хэмжээг Онцгой байдлын газарт эрх шилжүүлэн гүйцэтгүүлсэн байна.

2.9. Аймгийн Засаг даргын 2025 оны А/167 дугаар "Эрх шилжүүлэн гүйцэтгүүлэх тухай" захирамжаар Даланзадгад суманд эрх шилжсэн 3 тендер шалгаруулалтыг Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж, аймгийн ЗДТГ захиалагчийн эрх эдэлж, үүрэг хүлээсэн байна.

2.10. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7⁸, 48 дугаар зүйлийн 48.1⁹-д заасантай нийцэхгүй тул зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлсэн.

2.11. Тендерийг зохион байгуулж гүйцэтгэгчийг шалгаруулахдаа нийт төсөл, арга хэмжээний 52.1 хувьд нээлттэй тендер шалгаруулалт, 22.9 хувьд харьцуулалтын арга, 22.3 хувьд шууд худалдан авах аргыг ашигласан байна.

⁸ 45.7 Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх энэ хуулийн 45.1, 45.2, 45.3, 45.4-т зааснаас бусад төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг харьяалах доод шатны төсвийн захирагчид, эсхүл худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн бол ажлын 10 өдрийн дотор шилжүүлнэ

⁹ Төсвийн шууд захирагч болон захиалагчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх бусад этгээд энэ хуульд заасан захиалагчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ

Хүснэгт 9: ХАА-нд мөрдөгдсөн журам

№	Аймаг, сумд	ХАА амжилттай			ХАА-нд мөрдөгдсөн журам			
		ТАХ-ний тоо	Гэрээний дүн /сая төг/	НТШ	ХА	ШХА	ГШБ	Төрийн нууцад хамаарах
1	Аймаг	155	83,159.2	108	28	26	2	5
2	Баяндалай	2	326.8	1	1	-	-	-
3	Баян-Овоо	5	105.8	2	2	5	-	-
4	Гурвантэс	18	4,666.2	9	5	5	1	-
5	Даланзадгад	57	25,905.3	31	18	11	-	-
6	Манлай	4	4,228.7	3	1	-	-	-
7	Номгон	1	215.9	1	-	-	-	-
8	Ноён	2	36.0	1	-	2	-	-
9	Сэврэй	8	3,122.2	5	3	-	-	-
10	Ханбогд	50	68,008.1	21	13	16	-	-
11	Ханхонгор	4	178.8	-	4	-	-	-
12	Хүрмэн	1	108.5	-	1	-	-	-
13	Цогт-Овоо	6	1,369.5	4	-	1	1	-
14	Цогтцэций	58	52,180.4	30	15	22	-	1
	Дүн	371	243,611.4	216	91	88	4	6

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгаа

2.12. Засгийн газрын 2024 оны 120 дугаар тогтоолоор баталсан "Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам"-ын дагуу 6 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

2.13. Аудитаар худалдан авах ажиллагааг зохион байгуулахтай холбоотой дараах зөрчил, дутагдлууд илэрсэн байна. Үүнд:

- Худалдан авах ажиллагааг үнэлэхдээ Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар"-ын маягтыг ашиглаагүй;
- Тендерийн үр дүнгийн талаарх захиалагчийн шийдвэрийг гарсан өдөр нь худалдан авах ажиллагааны цахим системд нийтлээгүй;
- Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журмын дагуу худалдан ажиллагааг зохион байгуулаагүй;
- Үнийн хөнгөлөлт тооцож захиалагчид зөвлөмж хүргүүлээгүй;
- Тендер шалгаруулалтын хувийн хэргийн баримтын бүрдлийг хангаагүй, архивын нэгж үүсгээгүй;
- Тендер шалгаруулалтын тендер хүлээн авах хуулийн хугацааг баримтлаагүй;
- Гэрээ байгуулах эрх олгох шийдвэр, мэдэгдлийг хуулийн хугацаанд хүргүүлээгүй;
- Худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй байна.

Хүснэгт 10: Хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй ХАА

сая төгрөг

№	АЙМАГ, СУМД	ТАХ-НЫ ТОО	ТӨСӨВТ ӨРТӨГ
1	Даланзадгад	1	400.0
2	Гурвантэс	1	89.8
3	Сэврэй	1	38.6
4	Ханхонгор	2	59.3
5	Ханбогд	7	5,356.2
6	Цогтцэций	28	14,591.9
	Дүн	40	20,535.8

2.14. Дээрх зөрчлүүд нь худалдан авах ажиллагааны мэргэжлийн боловсон хүчин хангалтгүй, байгууллагын дотоод хяналт сул байгаатай холбоотой байна.

2.15. Иймд дээрх зөрчил гаргасан төсвийн захирагч нарт зөрчил давтахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

2.16. Өмнөговь аймгийн Ханбогд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 2/07 дугаар тогтоолоор баталсан 7,900.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "280 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих" ажлын тендер хүлээн авах хугацаанд тодруулга хийж нийт төсөвт өртгийг батлагдсан төсвөөс нэмэгдүүлэн 12,936.7 сая төгрөгөөр тендер зарласан байна.

2.17. "Ханбогд сумын 1 дүгээр сургуулийн Б байрны камержуулалт, 2 дугаар сургуулийн дотор камержуулалт" 113.6 сая, "Хөнгөн үйлдвэрийн бүсийг цэвэр, бохир, цахилгаан, дулаан, холбоо дохиоллын магистрал шугамд холбох" 3,220.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлуудын тендер шалгаруулалттай холбоотой гарсан гомдлыг хянасан Монгол Улсын Сангийн яамны шийдвэрийн дагуу холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна.

2.18. Мөн "Ханбогд сумын 2 дугаар сургуулийн багш ажилчдын 60 айлын орон сууцны зураг төсөв" боловсруулах ажлыг худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй "Архидеа" ХХК-тай 370.0 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулсан.

2.19. Дээрх зөрчилд Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу зөрчил давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлж, мөн гэмт хэргийн шинжтэй байх болзошгүй гэж үзэн Монгол Улсын Ерөнхий аудиторт хүргүүлсэн.

2.20. Орон нутгийн төсвийн 2025 онд хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтын аргыг хуульд заасны дагуу хэрэглэх, тендер шалгаруулалтыг хуульд заасан хугацаанд зохион байгуулах, шийдвэр гаргах, үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавих захиалагчийн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй Ханбогд сумын Засаг даргад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлээ.

2.21. Номгон сумын Баянбулаг булгийн эхийг хашиж хамгаалах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо нь Тендерийн баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлагын дагуу үнэлгээ зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

2.22. Тайлант онд тендерт оролцогчдоос 23 гомдол гарсан бөгөөд худалдан авах ажиллагаанд гарсан гомдол шийдвэрлэлтийн 69.5 хувийг захиалагчийн шийдвэр үндэслэлгүй гэж Сангийн яамнаас хянасан байна.

2.23. Иймд худалдан авах ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

В.1 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжүүлээгүй, гэрээний дагуу хариуцлага тооцож, холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

3.1 Аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 594,052.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 589 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 546,029.7 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Хүснэгт №11 Төсөл арга хэмжээний гэрээний хэрэгжилтийн байдал				/сая төгрөг/	
ГҮЙЦЭТГЭЛ	ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОО	ТӨСӨВТ ӨРТӨГ	ГЭРЭЭНИЙ ДҮН	ХЭРЭГЖИЛТ ХУВИАР	
ХЭРЭГЖИЖ ДУУССАН	480	353,209.4	332,448.8	81.5	
ХЭРЭГЖИЛТ ДУТУУ	84	208,135.7	181,989.3	14.3	
ХЭРЭГЖЭЭГҮЙ	25	32,707.4	31,591.7	4.2	
НИЙТ ДҮН	589	594,052.6	546,029.7	100	

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгаа

3.2 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр байгуулсан нийт гэрээний 81.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 14.3 хувь нь хэрэгжилт дутуу, 4.2 хувь нь хэрэгжээгүй байна.

3.3 Хэрэгжилт дутуу ажлын 46.4 хувийг зураг төсөв, зөвлөх үйлчилгээний ажил эзэлж байгаа бөгөөд доорх нөхцөл байдлаас шалтгаалсан байна. Үүнд:

- Хангагч байгууллага техникийн нөхцөл хуулийн хугацаанд гаргаж ирүүлээгүй;
- Техникийн нөхцөлийг Эрчим хүчний яамнаас гаргуулах асуудал удааширсан;
- Барилгын хүчитгэлийн дүгнэлт хийгээгүй;
- Зураг төслийн төлөвлөлтийн шийдэл батлагдаагүй, зөвшилцөлд хүрээгүй;
- Газар олголтын асуудлаас шалтгаалан ажил удааширсан;
- Гүйцэтгэгч гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн;
- Төсвийн зарцуулалтын эрхтэй холбогдуулан он дамжуулан гүйцэтгэлийн санхүүжилт олгосон

3.4 Төсвийн зарцуулалтын эрхтэй холбогдуулан он дамжуулан гүйцэтгэлийн санхүүжилтийг олгосон зураг төслийг 2026 оны 1, 2 дугаар улиралд хүлээн авч гэрээ дүгнэсэн байна.

3.5 Гүйцэтгэгчээс шалтгаалан ажил удааширсан, төлөвлөсөн хугацаанд ажил гүйцэтгээгүй байгууллагад гэрээний дагуу хариуцлага тооцож, алданги ногдуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллах албан шаардлагыг холбогдох төсвийн захирагчид хүргүүллээ.

3.6 Хэрэгжилт дутуу авто зам, барилга байгууламж барих, их засварын ажлын хөрөнгө оруулалтууд нь гэрээний дагуу он дамжин хэрэгжихээр төлөвлөгдсөн, хугацаа сунгасан, гэрээний үүргээ хангаагүй, зураг зохиогч, захиалагч, гүйцэтгэгч зөвшилцөн ажлын зураг, тоо хэмжээ, материал өөрчилснөөс ажил удааширсан, төсвийн зарцуулалтын эрхтэй

холбогдуулан он дамжиж гүйцэтгэлийн санхүүжилт олгосон, улсын комисс хүлээж аваагүй зэргээс шалтгаалсан байна.

3.7 Хэрэгжээгүй төсөл арга хэмжээний 44 хувийг гэрээ байгуулагдсан боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1¹⁰, 13.1.2¹¹ заалтыг үндэслэн гэрээ цуцалсан төсөл арга хэмжээ эзэлж байна.

3.8 Мөн шүүхэд гомдол гарсан, барилгын ажлыг дутуу хийгээд орхисон, зураг төсөв магадлалаар баталгаажаагүйгээс барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгогдоогүй, ашиглагч сумдын санал болгосон байршилд сүлжээ муу байгаагаас шалтгаалан хийгдээгүй, захиалагчийн шаардлагад нийцээгүйгээс зураг төслийг хүлээж аваагүй засвар сайжруулалт хийлгэж байгаа, оны сүүлээр гэрээ байгуулсан зэрэг ажлууд бүрэн хэрэгжээгүй байна.

3.9 Дээрх зөрчил дутагдлыг арилгуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллах албан шаардлагыг төсвийн захирагч нарт хүргүүлээ.

3.10 Аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлсэн 550 төсөл, арга хэмжээнд 276,552.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хүснэгт №12 Төсөл арга хэмжээнд олгосон санхүүжилт /сая төгрөг/

ШИНЭ, ШИЛЖИХ	ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОО	2025 ОНД САНХҮҮЖИХ ДҮН	ГЭРЭЭНИЙ ДҮН	ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ
ШИНЭ	363	178,859.6	227,520.9	160,117.5
ШИЛЖИХ	187	145,403.0	285,486.0	116,435.1
НИЙТ ДҮН	550	324,262.6	513,006.9	276,552.6

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгаа

3.11 Төсвийн хөрөнгө оруулалтын 318 төсөл арга хэмжээнд 75,623.8 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" 2025 оны 05 албан даалгавар болон Сангийн яамнаас зарцуулалтын эрх нээгээгүйгээс зарим төсөл арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгоогүй байна.

3.12 АИТХ-ын тогтоолын дагуу 2026 онд дамжин хэрэгжих 47,532.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл арга хэмжээнд батлагдсан төсвийн дагуу 23,550.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

3.13 "Даланзадгад-Ханхонгор чиглэлийн хатуу хучилттай автозам барих" ажилд 1,083.6 сая, "Даланзадгад суманд тэмээний төрөлжсөн мал эмнэлгийн барилгыг барьж ашиглалтад оруулах" ажилд 110.8 сая төгрөгөөр тус тус нэмэлт гэрээ байгуулж санхүүжилт олгосон байна.

3.14 Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад батлаагүй 8 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн 414.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

¹⁰ 13.1.1. батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;

¹¹ 13.1.2. энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох;

3.15 Цогтцэций сумын Засаг дарга "Цогтцэций суманд 640 хүүхдийн сургууль барих" ажлын 2025 оны санхүүжилт 4,197.4 сая төгрөгийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй, Төрийн үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор ЗДТГ-ын архивын өрөөг засварлах, тохижуулах, тоног төхөөрөмжөөр хангах ажил, гэрээт цагдаагийн албыг тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах ажил зэрэг шууд худалдан авалтын гэрээний хэрэгжилт хангагдаагүй байхад урьдчилгаа төлбөр олгосон байна.

3.16 Дээрх илэрсэн зөрчлүүдэд дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

3.17 Манлай сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 245.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Засаг даргын Тамгын газрын автомашинд шинэчлэл хийх" ажлын гэрээнд тусгагдсан чанарын барьцаа 12.5 сая, Ханхонгор сумын "Жаргалант багт Ногоон байгууламжийг нэмэгдүүлж элсний нүүдлээс хамгаалах" ажлын 1.4 сая төгрөгийг тус тус барьцаа дансанд төвлөрүүлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3.18 Цогтцэций сум төсвийн хөрөнгө оруулалтын данснаас барьцаа дансанд 21.4 сая төгрөгийг давхардуулан шилжүүлсэн, гэрээний дагуу ногдуулсан алданги 3.0 сая төгрөгийг төсвийн орлогод төвлөрүүлээгүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

3.19 Хөрөнгө оруулалтын зардлаас 2025 онд зарцуулаагүй санхүүжилтийн үлдэгдлийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан зөрчил гараагүй бөгөөд өмнөх онуудад Төрийн сан банк дахь Барьцаа хөрөнгийн 100110051410 тоот дансанд хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний зардлаас байршуулсан 4,444.2 сая төгрөгийг төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

3.20 Дээрх зөрчил дутагдлаас үзэхэд төрийн сангийн төлбөр тооцооны гүйлгээнд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

3.21 Олон улсын шаардлагад нийцсэн бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох "Сорилын төв" байгуулах ажлын хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг зах зээлийн дунджаас дээгүүр үнээр худалдан авсан нь Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасны дагуу гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзэн Монгол Улсын Ерөнхий аудиторт шилжүүлэхээр шийдвэрлэлээ.

3.22 Аймаг, сумын онцгой комисст туулах чадвар сайтай автомашин нийлүүлэх, төрийн байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлэх, шуурхай хүргэх зорилгоор төрийн байгууллагад автомашин худалдан авах хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж аймгийн ЗДТГ 1,476.6 сая, Баяндалай сум 249.9 сая, Сэврэй сум 319.4 сая, Цогт-Овоо сум 249.8 сая, Цогтцэций сум 1,341.9 сая, Ханбогд сум 856.14 сая төгрөгөөр тус тус худалдан авалт хийсэн байна.

3.23 Төсвийн хөрөнгөөр өндөр үнэтэй худалдан авалт хийж байгаа нь төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах төсвийн зарчимтай нийцээгүй байна.

3.24 Төсөл, арга хэмжээг ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсвийн дагуу чанартай гүйцэтгүүлсэн эсэхэд горим сорил хэрэгжүүлэхэд аудитын явцад дараах зөрчил дутагдал ирлээ. Үүнд:

- Аймгийн Засаг даргаас эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн Сэврэй суманд 10 айлын орон сууц барьж, ашиглалтад оруулах ажлыг Отгоннинж ХХК гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн ч тохижилтын ажил хийгээгүй, байрны халаалт доголдолтой байхад комисс хүлээж авсан, хийгдээгүй ажлын төсвийг тооцож хариуцлага тооцоогүй байна.

Зураг №01 Сэврэй сумын 10 айлын орон сууцны барилгын гадна тохижилт хийгдээгүй байдал



- Ханхонгор суманд 10 айлын орон сууц барьж, ашиглалтад оруулах ажлыг төсвийн 1,260.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн Бизнес фокус ХХК гадна тохижилтын ажил, 0.4 шугамын дэд өртөө бүрэн хийгдээгүй байхад улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан байна.

Зураг №02 Ханхонгор сумын 10 айлын орон сууцны барилгын гадна тохижилт хийгдээгүй байдал



- Өмнөговь аймгийн Ханбогд сумын "Онцгой байдлын хэлтсийн сургалтын төвийн барилгыг барьж ашиглалтад оруулах" ажлыг Энхбодиз ХХК гүйцэтгэж Улсын комиссын үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авсан боловч ангийн халаалтын төвийн шугам сүлжээ хийгдээгүй, бохирын шугам төвийн шугамд холбогдоогүй, цутгалтын багана болон дүүргэлтийн хана хооронд хагарал үүссэн, таазны замаск хууларсан, душ, сауны өрөөнд халуун ус байхгүй, усны даралт муу, үүдний шилэн хаалга хагархай, цонхны резин байхгүй, порчигны нугас дутуу, галын дохиолол, гидрантын холболт хийгдээгүй, халаалтын буцах шугам буруу тавигдсан, зарим өрөөний паар халахгүй, ус алдсан, усны шугамын бэхэлгээ дутуу зэрэг зөрчилтэй байхад барилга байгууламжийн өрлөг, заслын ажлын стандартад техникийн хяналтыг хэрэгжүүлээгүй, комисс журмын дагуу ашиглалтад хүлээн аваагүй байна.

Зураг №03 Ханбогд сумын Онцгой байдлын хэлтсийн сургалтын төвийн барилга



- Улсын нөөцийн 114 дүгээр салбарын байр, агуулахын барилгыг хүчитгэж гадна фасадын ажлыг 468.0 сая төгрөгөөр хийлгэж хүлээж авсан бөгөөд ажлын тоо хэмжээ зөрүүтэй, 3 объектын гадна ханыг метал хавтанцраар дулаалгатай өнгөлөх, тэжээлийн жижиг агуулахын цонх задалж буулгах, бүргэд хаалга суулгах, конторын барилгын ус зайлуулах хоолой хийх, гадна хашаа засварын 1 том хаалга хийх зэрэг ажлууд дутуу хийгдсэн байна.

Зураг №04 Улсын нөөцийн 114 дүгээр салбарын байр, агуулахын барилгын засварын дараах зураг




- Гурвантэс сумын төсвийн 1,155.6 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн дунд сургуулийн барилгын их засварын зураг төсөл зургийн даалгавраас зөрүүтэй хийгдсэн байхад захиалагч хүлээн авч 2025 оны хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлснээс зураг төсөл, ажлын тоо хэмжээнд тусгагдсан ажлууд бүрэн хийгдээгүй байна.

Зураг №05 Гурвантэс сумын дунд сургуулийн барилга



- Орон нутгийн 3,128.5 сая төгрөгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Ханбогд сумын Цагдаагийн хэлтсийн барилга барьж эхлүүлэх" ажлын 1 давхрын ариун цэврийн өрөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хэсгийг тохижуулаагүй, аваарын гарц хаалга болон шатны хэсгийн цонхыг зураг төсөвт тусгагдсанаас зөрүүтэй хийсэн байна.

Зураг №06 Ханбогд сумын Цагдаагийн хэлтсийн барилга



- Даланзадгад суманд тэмээний төрөлжсөн мал эмнэлгийн барилгыг барьж ашиглалтад оруулах ажлыг төсвийн 2,571.03 сая төгрөгөөр Бадрахмандал Шим ХХК гүйцэтгэн Улсын комиссын үүрэг даалгаврын биелэлтээр 2025 оны 10 сард хүлээн авсан боловч барилга байгууламжийн хойд болон зүүн тал, төв хаалганы орчимд барилгын хаяавч хэсэг газраар суулт өгч, барилгын дотор өрөө тусгаарлах хананы нэг талд цууралт өгсөн, мал, амьтан оруулах, гаргах зориулалт бүхий урд, баруун талын 3 хаалга эргэн тойрон завсар гарч тоос, шороо орсон ба гадна тохижилт, ногоон байгууламжийн ажлууд хийгдээгүй байна.

Зураг №07 Даланзадгад суман дахь Тэмээний төрөлжсөн мал эмнэлгийн барилга



- Эрүүл мэндийн төвийг туулах чадвар сайтай автомашинаар хангах, Great Wall Tank 500 маркийн автомашины хөдөлгүүрийн багтаамж зөрүүтэй, Төрийн байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлэх, шуурхай хүргэх зорилгоор төрийн байгууллагад автомашин авах Great Wall Tank 500, Цагдаагийн хэлтэст алсын болон ойрын дуудлагын тээврийн хэрэгсэл худалдан авах ажлын Great Wall Tank 500 маркийн автомашинуудыг нийлүүлэх гэрээ, техникийн тодорхойлолтод заасан 2025 онд үйлдвэрлэгдсэн байна гэсэн шаардлагыг хангаагүй байхад комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна.

Зураг №08 Цогтцэций сумын Эрүүл мэндийн төвийн Great Wall Tank 500 маркийн автомашин



- Цогтцэций сумын "Тэгш дүүрэн тохижилт" ОНӨААТҮГ-ыг хог хаягдал тээвэрлэх машин, техник хэрэгслээр хангах ажлын хүрээнд хүлээн авсан Dongfong маркийн автомашин нь ашиглалтын явц нормоос 40-50 литр шатахуун илүү зарцуулалттай байна.

Зураг №9 "Тэгш дүүрэн тохижилт" ОНӨААТҮГ-ыг хог хаягдал тээвэрлэх машин



- Тэгшдүүрэн тохижилт ОНӨААТҮГ-ын барилга болон тавилга, тоног төхөөрөмжөөр хангах ажлын галын дохиоллын холболт хийгдээгүй, цементэн талбайн хайрга бутарсан байна.

Зураг №10 "Тэгш дүүрэн тохижилт" ОНӨААТҮГ-ын барилга



- Мөн Цогтцэций сумын Эрүүл мэндийн төвийн 2-р давхрын засварын ажлын ханын булангийн хамгаалалтууд ховхорч унасан,

- Ханбогд сум дахь сум дундын прокурорын газрын барилгын дотор засвар"-ын ажлыг төсвийн 32.2 сая төгрөгөөр хэрэгжүүлэхдээ ажлын даалгаврын дагуу гүйцэтгээгүй,

- "Ханбогд сумын 2 дугаар сургууль, 29 дүгээр цэцэрлэгийн барилгын хаалга, цонхны засвар"-ын ажлыг "Эрхэм баян амгалан" ХХК-аар 552.0 сая төгрөгийн гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч ажлын даалгаварт тусгагдсан 603м² вакум цонхонд хамгаалалтын торыг суулгаагүй байхад ажил хүлээлцэх комисс хүлээн авсан,

- Даланзадгад сумын 3-р сургуулийн барилгын их засварын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгүүлээгүй, ашиглагч байгууллага зургийн даалгаврыг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулаагүй, ажлын гүйцэтгэлийн явцад өөрчлөлт оруулан тухайн ажлын гүйцэтгүүлсэн бөгөөд хийгдээгүй ажлын төсвийн зөрүүг гаргуулаагүй байна.

3.25 Төсөл арга хэмжээний зургийн даалгавар, ажлын даалгавар, тоо хэмжээг бодитой төлөвлөж зураг төсөв боловсруулж, батлуулаагүйгээс дээрх зөрчил дутагдлууд үүсэж хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна.

3.26 Дээрх зөрчлүүдийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг төсвийн захирагч нарт хүргүүлээ.

3.27 Цогтцэций сум "Төрийн албанд тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн баталгааг хангах хүрээнд "Шинэ мянган айл" орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлж, төсвийн 2,501.6 сая төгрөгийн хөрөнгөөр 16 айлын төрийн албан хаагчийн орон сууц барих төсөл арга хэмжээг баталсан боловч, орон сууц худалдан авах тендер зарлаж тус ажлыг хэрэгжүүлсэн байна. Дээрх зөрчилд албан шаардлага хүргүүлсэн бөгөөд уг асуудал хуулийн байгууллага шалгагдаж байна.

3.28 Аймгийн Засаг даргаас эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн "Шинэ мянган айл" хөтөлбөрийн хүрээнд Ноён суманд 10 айлын орон сууц барих ажлын тендерийг 2023 онд 2 удаа зарлагдан амжилтгүй болж Тэргүүн констракшн ХХК-тай 1,400.0 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулж ажилласан боловч уг барилгын ажил 2 жил зогссон байхад эрх бүхий байгууллагаас холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Зураг №11 Ноён сумын 10 айлын орон сууцны барилгын ажлын явц



3.29 Шинэ мянган айл хөтөлбөрийн хүрээнд Даланзадгад суманд түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх ажил гүйцэтгэж буй байгууллагын гэрээний хэрэгжилтэд захиалагч хяналт тавьж, гүйцэтгэлээр санхүүжилт олгодоггүй, хариуцлага тооцдоггүй, гэрээний хугацааг сунгаж ажил удаашруулсан зөрчил давтан гарсаар байна.

3.30 Цогтцэций сумын ЗДТГ-ын гадна тохижилт, засварын ажил, Цогтцэций сумын 10 айлын орон сууцны барилгын гадна тохижилт хийх ажил ӨМАХААГ/20250101120 дугаартай гэрээг тус тус байгуулсан боловч төлөвлөсөн хугацаандаа дуусаагүй, гэрээний хугацааг удаа дараа сунгасан, гэрээнд заасны дагуу алданги ногдуулж, хариуцлага тооцоогүй, гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллаагүй байна.

Зураг № 12 Цогтцэций сумын 10 айлын орон сууцны гадна тохижилтын ажлын явц



3.31 Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн Штабын барилгыг барих ажлыг 2024-2026 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн ч барилгын ажлын гүйцэтгэл 38.1 хувьтай байгаа нь төлөвлөсөн хугацаанд ашиглалтад хүлээлгэн өгөхгүй байх эрсдэлийг үүсгэсэн байна.

3.32 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлж, дүгнэн холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

В.2. Барилга байгууламжийн үе шат бүрд зохиогчийн хяналтаар илэрсэн зөрчил дутагдал өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, захиалагчийн хяналтыг чанартай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3.33 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд нийт 271,257.51 сая төгрөгийн 100 барилга байгууламжийн ажил гүйцэтгэсэн байна.

Хүснэгт-13. ОНТХО-аар 2025 онд хийгдэх барилга, байгууламжийн ажил (сая.төгрөг)

№	Аймаг, Сумд	Төсөл арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Зохиогч, захиалагчийн хяналтын зардал
1	Аймаг	74	146,401.1	143,544.5	1,969.0
2	Баян-Овоо	1	7.0	7.0	-
3	Гурвантэс	3	1,551.9	1,525.5	24.3
4	Даланзадгад	3	2,322.7	2,270.3	24.7
5	Сэврэй	2	138.4	138.4	-
6	Ханбогд	16	133,813.1	121,270.2	544.3
7	Цогтцэций	1	2,541.0	2,501.6	-
	<i>Нийт</i>	100	286,775.2	271,257.5	48.9

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгаа

3.34 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар болон “Өмнөговь корпорац” ОНӨААТҮГ, мэргэжлийн хуулийн этгээд болон мэргэжлийн зөвлөх инженерүүдтэй гэрээ байгуулан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

3.35 Зарим сумдын хэрэгжүүлж буй барилга байгууламж, их засвар тохижилтын ажилд зохиогчийн болон захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлсэн талаар тайлан байхгүй, акт, фото зургаар баталгаажуулаагүй байна. Үүнд:

- Гурвантэс сумын “Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны засварын ажлын ӨГАГТСЗДТГ/202501011009 дугаар гэрээнд заасны дагуу зохиогч, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй;
- Гурвантэс сум нь захиалагчийн хяналтын зардлыг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай 80 хувиар олгохоор тооцож гэрээ байгуулсан, захиалагчаас хамтарсан үзлэг шалгалт хийсэн нь баримтаар нотлогдоогүй;
- Сэврэй сумын “Засмал зам дагуух сумын хилийн цэс газарт тохижилт хийх”, “Сумын төрийн үйлчилгээний авто машины граш барих” ажлуудад захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй;
- Даланзадгад сумын “Цагаанбулаг 8 дугаар багийн мод үржүүлэг хорооллын баруун талын үерийн даланг засварлаж, тохижуулах”, “Дунд сайхны 4 дүгээр багт тоглоомын талбай байгуулах”, “Гурвансайхан хорооллын шинээр баригдаж буй автозам дагуух үерийн усны сувагжилд хийх”, “Ерөнхий боловсролын сургуулиудын бие засах газрыг засварлах” зэрэг ажлуудад захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлээгүй;

- Даланзадгад сумын “Зүүн сайхан 5 дугаар багийн цогцолбор тоглоомын талбайн ажил”, “Дунд сайхны 4 дүгээр багт тоглоомын талбай байгуулах”, “Гурвансайхан хорооллын шинээр баригдаж буй автозам дагуух үерийн усны сувагжилт хийх”, “Төрийн албан хаагчдыг шаардлагатай тавилга, техник, тоног төхөөрөмжөөр хангах Багц-2”, “Даланзадгадын дулаан хангамжийн газар ОНӨААТҮГ-ын дулаан хангамжийн төвүүдийн барилгын засвар”-ын ажлуудад зохиогчтой гэрээ байгуулж, зохиогчийн хяналт хийлгээгүй;
- Цогтцэций сум нь хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг гэрээнд тусгасны дагуу зохиогчийн хяналт, захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх гэрээ байгуулж, хяналт хийлгэсэн эсэх нь баримтаар нотлогдоогүй байна.

3.36 Иймд дээрх зөрчил дутагдлыг арилгах, зөрчил давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлсэн.

3.37 Цаашид сумдад хэрэгжүүлж буй барилга байгууламж, их засвар тохижилтын ажилд зохиогчийн болон захиалагчийн техникийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, хяналтын тайланг баталгаажуулж ажиллах шаардлагатай байна.

3.38 Барилгын ажлыг зураг төсөл, баримт бичигт заасан техникийн үзүүлэлтээс зөрүүтэй, дутуу гүйцэтгэсэн дараах төсөл арга хэмжээг улсын комисс хүлээж авсан байна. Үүнд:

- Ханбогд сумын "Ханбогд сумын 2 дугаар сургууль 29 дүгээр цэцэрлэгийн барилгын хаалга, цонхны засвар"-ын ажлын даалгаварт тусгагдсан 603м2 вакуум цонхонд хамгаалалтын торыг суулгаагүй;
- “Ханбогд сумын Цагдаагийн хэлтсийн барилга барьж эхлүүлэх” ажлын 1 давхрын ариун цэврийн өрөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хэсгийг тохижуулаагүй, аваарын гарц хаалга болон шатны хэсгийн цонх зураг төсөвт тусгагдсанаас зөрүүтэй;
- Ханбогд сумын "Онцгой байдлын хэлтсийн сургалтын төвийн барилгыг барьж ашиглалтад оруулах" ажлыг Энхбодиз ХХК гүйцэтгэж Улсын комиссын үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авсан боловч ангийн халаалтын төвийн шугам сүлжээ хийгдээгүй, бохирын шугам төвийн шугамд холбогдоогүй;
- Сэврэй суманд 10 айлын орон сууц барьж, ашиглалтад оруулах /Отгоннинж ХХК/ ӨМАОНӨГ/202312048 дугаар гэрээт ажлын гадна тохижилтын ажил хийгдээгүй, байрны халаалт доголдолтой,
- Ханхонгор суманд 10 айлын орон сууц барьж, ашиглалтад оруулах /Бизнес фокус ХХК/ ӨМАОНӨГ/202312052 дугаар гэрээт ажлын гадна тохижилтын ажил дутуу, трансматорын дэд өртөө хийгээгүй,
- Улсын нөөцийн 114 дүгээр салбарын байр, агуулахын барилгыг хүчитгэж гадна фасадын ажил хийлгэж хүлээж авсан бөгөөд ажлын тоо хэмжээ зөрүүтэй, 3 объектын гадна ханыг метал хавтанцраар дулаалгатай өнгөлөх, тэжээлийн жижиг агуулахын цонх задалж буулгах, бүргэд хаалга суулгах, конторын барилгын ус зайлуулах хоолой хийх, гадна хашаа засварын 1 том хаалга хийх зэрэг ажлууд дутуу хийгдсэн байна.

3.39 Дээрх зөрчил дутагдлыг арилгах ажлыг зохион байгуулж, зөрчил давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлж ажиллаа.

3.40 Цаашид Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламж ашиглалтад оруулах дүрэм”-ийн 5.1¹² -г заасан чиг үүргийг баримталж барилгын ажлыг зураг төсөл, норм, нормативын баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

3.41 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний захиалагч болон захиалагчийн техникийн хяналтыг сайжруулах, ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

В.3 Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмжийг зориулалт, хүчин чадлын дагуу ашиглалтад оруулж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцож ажиллах шаардлагатай байна.

3.42 Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээг он дамжуулан хэрэгжүүлж хүлээж авсан боловч уг хөрөнгийг хүчин чадал, зориулалтын дагуу ашиглаагүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна. Үүнд:

- Даланзадгад суманд "Худалдааны төв зах"-ын үйл ажиллагааг явуулах, I, II ээлжийн барилга байгууламжийн ажлыг 1,047.7 сая төгрөгөөр 2022-2025 онд хэрэгжүүлсэн ч төвийн цахилгаан, дулаан, цэвэр бохирын шугамын ажлууд хийгдээгүй, шаардлагад нийцүүлэн оновчтой төлөвлөөгүйгээс одоог хүртэл уг худалдааны зах ашиглалтгүй, бүтээн байгуулалтын ажлууд элэгдэлд орж эвдэрсэн байдалтай байна.

Зураг №13 "Худалдааны төв зах"-ын барилга байгууламж



Булган суманд худалдаа, үйлчилгээ, мэдээллийн төв, нийтийн ариун цэврийн байгууламж барих ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгийн 849.2 сая төгрөгөөр хэрэгжүүлэн 2025 оны 9 сард барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан ч зориулалтын дагуу ашиглаагүй байна.

Зураг №14 Булган сумын худалдаа, үйлчилгээ, мэдээллийн төвийн барилга



¹² 5.1.Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- Даланзадгайн цэцэрлэгт хүрээлэн байгуулах-Багц-3 ажлыг төсвийн 1,075.5 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр 2023 онд эхлүүлсэн ч захиалагчаас ажлын зургийг өөрчилсөнтэй холбоотойгоор төлөвлөсөн хугацаанд ажил хэрэгжээгүй, цөөрөм, усалгааны шугам хоолойн ажлын зураг, төсөв 2025 оны 04 сард магадлалын дүгнэлтээр баталгаажсан бөгөөд мэдээллийн төвийн барилгыг 2024 онд хүлээн авсан ч зориулалтын дагуу ашиглаагүй байна.

Зураг №15 Даланзадгайн цэцэрлэгт хүрээлэнгийн сургалт мэдээллийн төвийн барилга



- "Даланзадгад суманд тэмээний төрөлжсөн мал эмнэлгийн барилгыг барьж ашиглалтад оруулах" ажлыг төсвийн 2,571.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэн 2025 оны 10 дугаар сард ашиглалтад хүлээн авсан ч орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах асуудал шийдэгдээгүйгээс одоог хүртэл ашиглалтад оруулаагүй оффисын барилга, тоног төхөөрөмжийн хамт ашиглалтгүй байна.

Зураг №16 Даланзадгад сум дахь Тэмээний төрөлжсөн мал эмнэлгийн барилга



- Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн барилга барих ажлыг тоног төхөөрөмжийн хамт төлөвлөн хэрэгжүүлсэн ч уг үйлдвэр тоног төхөөрөмжийг хүчин чадал зориулалтын дагуу ашиглаагүй байна.

Зураг №17 Даланзадгад сум дахь Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмж



- "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд Цогт-Овоо суманд төсвийн 546.5 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн мал нядалгааны газрыг 2025 оны 12 дугаар сард ашиглалтад хүлээн авсан боловч тоног төхөөрөмж, тохижилтын ажлыг хамт төлөвлөгөөгүйгээс уг хөрөнгийг зориулалтын дагуу хүчин чадлаар нь ашиглах боломжгүй байна.

Зураг №18 Цогт-Овоо суманд барьсан мал нядалгааны газрын барилга



- Ханхонгор сум байгаль хамгаалах чиглэлийн хөрөнгө оруулалтаар "Хог шатаах зуух" барих ажлыг төсвийн 26.8 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн боловч уг хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй байна.

Зураг №19 Ханхонгор сум дахь хог шатаах зуух



- Ерөнхий боловсролын сургуулиудад англи хэлний кабинет байгуулах ажлын хүрээнд 90 ширхэг таблет, 90 ширхэг чихэвчийг хүлээлгэн өгсөн боловч таблет болон чихэвчний оролт таарахгүйгээс шалтгаалан 4.4 сая төгрөгийн үнийн дүнтэй чихэвч ашиглагдахгүй байна.

- Зүүн сайхан 5 дугаар багийн цогцолбор тоглоомын талбайн ажлыг дуусгах, Дунд сайхны 4 дүгээр багт тоглоомын талбай байгуулах, "Чандмань 9 дүгээр багт чийрэгжүүлэлтийн талбай барих ажил"-ыг тус тус ашиглалтад оруулсан боловч сагсны шитний самбар хагарсан, хашлаганы тор урагдсан, талбайн цемент хагарсан, гэрлийн шон, явган замын гэрэлтүүлэг эвдэрч алга болсон, сандал, хогийн сав, талбайн тор болон бусад эд зүйлс эвдэрч хэмхэрсэн байдалтай байна.

Зураг №20 Чандмань 9 дүгээр багийн чийрэгжүүлэлтийн талбай



Зураг №21 Зүүнсайхан 5 дугаар баг, Дундсайхан 4 дүгээр багийн тоглоомын талбай



3.43 Нийтийн эзэмшлийн талбайд байгуулсан бүтээн байгуулалтын чанар, ашиглалт, хамгаалалт, хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

3.44 Гурвантэс, Цогтцэций сумдын Засаг дарга нь сумын цагдаагийн тасагтаа алсын болон ойрын дуудлагын тээврийн хэрэгсэл худалдан авах ажлыг зохион байгуулж Өмнөговь аймгийн Цагдаагийн газрын өмчлөлд шилжүүлэн сумын цагдаагийн тасагтаа хүлээлгэн өгсөн байна.

3.45 Дээрх зөрчил дутагдалд холбогдох төсвийн захирагчид зөрчил арилгуулах, давтан гаргахгүй байх тухай албан шаардлага хүргүүлсэн.

3.46 Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг хууль, тогтоомжийн дагуу бүртгэлд тусгасан байна.

3.47 Аймгийн Засаг даргын 2025 оны "Гэрээ байгуулж ажил гүйцэтгүүлэх тухай" захирамжуудаар хөрөнгө оруулалтын дүнд бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгахыг аймгийн Тамгын газрын хэлтсийн даргад үүрэг болгосон болон бүртгэх хуулийн этгээд тодорхойгүй нөхцөл үүсгэсэн зөрчилд зөрчил давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

3.48 Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн Дулааны цахилгаан станц хоолны газрын тохижилт, Даланзадгадын дулаан хангамжийн газар ОНӨААТҮГ-ын дулаан дамжуулах төвийн барилгын засварын ажил, 2 дугаар багийн цэвэр усны шугам сүлжээг нэмэгдүүлэх, Гүний ус ОНӨААТҮГ-ын хэвийн үйл ажиллагааг хангах зэрэг нийт 735.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгээгүй байсныг аудитын явцад бүртгүүлж зөрчлийг арилгууллаа.

3.49 Хүрмэн-Даланзадгад чиглэлийн хатуу хучилттай автозам барих 9,422.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг эргэлтийн хөрөнгөөр бүртгээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3.50 Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд сум, орон нутаг өргөжин тэлж, хөгжлийн шинэ шатанд гарч иргэдийн ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлж байна.

3.51 Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн иргэдийн талархлыг хүлээсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнээс дурдвал:

- Сэврэй сум нь төрийн үйлчилгээний авто машины граш барих ажлыг орон нутгийн төсвийн 99.8 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн байна. Уг хөрөнгө оруулалтын үр дүнд төрийн албаны автомашин байгалийн гамшигт үзэгдэл болон нар салхи шорооноос хамгаалагдаж өмчийн хадгалалт, хамгаалалт сайжирсан байна.


Зураг №22 Сэврэй сумын төрийн үйлчилгээний авто машины грашын барилга



Төвийн цахилгаан дулаан цэвэр усны шугамд бүрэн холбосон байна.

- Даланзадгад сумын 7-р багт 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг барьж ашиглалтад оруулах ажлыг төсвийн хөрөнгө оруулалтын 4,979.5 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн байна. Орон нутагт цэцэрлэг нэмэгдсэнээр боловсролын тэгш хүртээмж нэмэгдэж, ажлын байр шинээр бий болсон олон талын ач холбогдолтой байна.

Зураг №23 Даланзадгад сумын 7-р багт баригдсан 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга



- Цогтцэций сумын "Тэгш дүүрэн тохижилт" ОНӨААТҮГ-ыг хог тээвэрлэх машин, техник хэрэгслээр хангах ажлын хүрээнд зам талбайн ажилтнуудыг 3 дугуйтай мотоциклоор хангасан нь ажилчдын хөдөлмөрийг хөнгөлсөн иргэдийн талархлыг хүлээсэн байна.

Зураг №24 Тэгш дүүрэн тохижилт" ОНӨААТҮГ-ын хог тээвэрлэх 3 дугуйт мотоцикл



- Гурвантэс сумын залуучуудын хөгжлийн төвийг барьж ашиглалтад оруулах ажлыг төсвийн 3,959.8 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн нь тус сумын залуучууд чөлөөт цагаа зөв

боловсон өнгөрүүлэх, хүүхэд багачуудад дугуйлан секц явуулах, сурч хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.

Зураг № 25 Гурвантэс сумын залуучуудын хөгжлийн төвийн барилга



- Ахмад настан хөгжил хамгааллын үйлчилгээг сайжруулах зорилгоор Цогт-Овоо, Сэврэй сумдад ахмадын өргөө байгуулах ажлыг нийтдээ 3,384.5 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн бөгөөд тус сумдын ахмадууд тав тухтай орчинд ажиллаж амрах, чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх, эрүүл мэндээ сайжруулах дасгал хөдөлгөөн, иог хийх зэргээр үр дүнтэй ашиглаж байна.

Зураг №26 Сэврэй, Цогт-Овоо сумын ахмадын өргөөний барилга



3.52 Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож, бодлого зорилтын үр дүнд хүрсэн эсэхийг харьцуулан тайлагнаагүй байна.

3.53 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлж хэрэгжүүлснээр төлөвлөсөн бодлогын зорилтот үр дүнд хүрсэн байна.

3.54 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжилт 80 хувьтай үнэлэгдсэн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон богино дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан хэдий ч нэн тэргүүний хэрэгцээ, шаардлага, үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй байна.

- Төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж байгаа нь хэрэгжилт удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх шалтгаан болж байна.

- Төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулснаар худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд зохион байгуулж амжихгүй, барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгогдохгүй, төсөл, арга хэмжээ хэрэгжихгүй, ажлын гүйцэтгэл төлөвлөсөн хугацаандаа дуусахгүй байх, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлийг дагуулж байна.

- Төсөл, арга хэмжээний үнэ, өртгийн урьдчилсан судалгаа хийгээгүй, судалгаанд үндэслэн төсөвт өртгийг төлөвлөөгүй, санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэгш хуваарилж батлуулаагүй байна.

- Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн хэрэгжүүлэх, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

- Худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүдийн хариуцлага, ур чадварыг дээшлүүлэх, гомдлын мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжүүлээгүй, гэрээний дагуу хариуцлага тооцож, шаардлагатай арга хэмжээг авч ажиллаагүй байна.

- Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон ч төсвийн зарцуулалтын эрхтэй холбоотойгоор зарим төсөл арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгоогүй байна.

- Төрийн сангийн төлбөр тооцооны гүйлгээнд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

- Тендер шалгаруулалтаар зах зээлээс өндөр үнээр тансаг зэрэглэлийн автомашин худалдан авсан нь төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах төсвийн зарчимтай нийцээгүй байна.

- Зарим төсөл, арга хэмжээг зураг төсвийн дагуу гүйцэтгүүлээгүй, захиалагч, зохиогч, гүйцэтгэгч байгууллагууд зөвшилцсөн ч төсвийн зөрүү тооцож гаргаагүй байна.

- Төсөл арга хэмжээний зургийн даалгавар, ажлын даалгавар, тоо хэмжээг бодитой төлөвлөж зураг төсөв боловсруулж, батлуулаагүйгээс хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж, зөрчил дутагдлыг нэмэгдүүлж байна.

- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлж, дүгнэн холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

- Сумдад хэрэгжүүлж буй барилга байгууламж, их засвар тохижилтын ажилд зохиогчийн болон захиалагчийн техникийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, хяналтын тайланг баталгаажуулж ажиллах шаардлагатай байна.
- Барилгын ажлыг зураг төсөл, баримт бичигт заасан техникийн үзүүлэлтээс зөрүүтэй, дутуу гүйцэтгэсэн ажлыг улсын комисс хүлээж авсан байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний захиалагч болон захиалагчийн техникийн хяналтыг сайжруулах, мэргэжилтнүүдийн ур чадвар, ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
- Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээг он дамжуулан хэрэгжүүлж хүлээж авсан боловч уг хөрөнгийг хүчин чадал, зориулалтын дагуу ашиглаагүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.
- Нийтийн эзэмшлийн талбайд байгуулсан бүтээн байгуулалтын чанар, ашиглалт, хамгаалалт, хяналтыг сайжруулах шаардлагатай байна.
- Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд сум, орон нутаг өргөжин тэлж, хөгжлийн шинэ шатанд гарч иргэдийн ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлж байна.
- Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож, бодлогын зорилтын үр дүнд хүрсэн эсэхийг харьцуулан тайлагнаагүй байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлж хэрэгжүүлснээр төлөвлөсөн бодлогын зорилтот үр дүнд хүрсэн байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Н.Энхбат танаа:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөвлөлтийн шаардлага хангуулж нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тодорхойлон төлөвлөн, батлуулах;
- Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, дотоод хяналтыг сайжруулах;
- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэл, гэрээний хэрэгжилт, үр дүнд тавих хяналтыг сайжруулж ажиллах;
- Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг хүчин чадал, зориулалтын дагуу бүрэн ашиглах, хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх.

Сумдын Засаг дарга нарт:

- Худалдан авах ажиллагааг хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, үнэлгээний хорооны гишүүдийг мэргэшүүлэх, ур чадвар, хариуцлагыг дээшлүүлэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд хэрэгжүүлэх захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, хамтарсан үзлэг шалгалт хийх;
- Төрийн сангийн төлбөр тооцооны гүйлгээнд тавих дотоод хяналтыг сайжруулах, гүйцэтгэлээр санхүүжилт олгох.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАХ ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/17

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Нийслэл дэх Төрийн Аудитын газар, аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга нарт хүргүүлэхийг Ахлах аудитор (С.Одончимэг)-т үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, тогтоосон төлбөрийн актыг бүртгэж, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг аудитор (М.Номиндарь)-т даалгасугай.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2027 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг Аймаг, сумдын Засаг дарга нарт зөвлөсүгэй.

5. Аудитын тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан ажлын болон нотлох баримтаар хадгаламжийн нэгж үүсгэн архивд хүлээлгэн өгөхийг аудитор (Н.Хулан)-д үүрэг болгосугай.



Ц.ӨСӨХБАЯР

4626010028

**Монгол улс, Өмнөговь аймаг, Даланзадгад сум 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон 3 давхар
Утас: +976 70533559, +976 70533552
И –мэйл: umnugovi@audit.gov.mn,
Вебсайт: www.audit.mn**